“МОНГОЛ БАЗАЛЬТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04-р сарын 17-ны өдөр № 01 Улаанбаатар хот

Хурал: 2023 оны 04 сарын 17-ны өдрийн 14.20 цагт Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр 7 давхарт байрлах “Монгол базальт” ХК-ийн хурлын танхимд цахим, танхим хосолсон хэлбэрээр хийгдэв. Хурлын явцыг Join Zoom Meeting холболтыг ашиглан шууд дамжуулсан ба хурлын ирц бүртгэл санал хураалтыг Си Эм Си Консалтинг ХХК-ийн боловсруулсан hural.basaltwool.mn цахим хуудас ашиглан явуулсан болно.

Хурлын ирц: Хуралд нийт 40,755,565 ширхэг хувьцаа эзэмшиж буй 28 хувьцаа эзэмшигч оролцсоноос танхимд 28 хувьцаа эзэмшигч ирсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц болон хурал хүчин төгөлдөр болсон тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай 04 дугаартай тогтолоор томилогдсон Тооллогын комиссын 2023.04.17-ны өдрийн 01 дугаартай тогтоолыг Тооллогын комиссын дарга Б.Болортуяа уншиж танилцуулав.

Тогтоолд: “Монгол базальт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 56,417,000 ширхэг хувьцаа эзэмшдэг 2467 хувьцаа эзэмшигчдээс 28 хувьцаа эзэмшигч ирж хуралд оролцсон нь 40,755,565 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 72,24% болж Хувьцаа Эзэмшигчдийн Хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээж, хуралд биечлэн оролцож буй бусад зочдыг танилцуулав.
Хурлын дарга А.Энхгэрэл: Сайн байцгаана уу. Цаг заваа зориулан хуралдаа ирсэн та бүхэндээ баярлалаа. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчидээс гадна Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ш.Энхтөр, Ч.Зоригтбаатар, ердийн гишүүн Б.Шаравсамбуу, Г.Ганзориг нар, Хөндлөнгийн аудит хийж дүгнэлт гаргасан “Нексиа Глобал Монголиа Аудит” ХХК-ийн аудитор Э.Бат-Оргил, Үнэт цаасны Апекс монголиа ХХК-ийн төлөөлөгч, Таван богд капитал ХХК-ийн төлөөлөгч нар хүрэлцэн ирсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хувьцаа эзэмшигчдийн танилцах материал болон Компанийн 2022 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг нэгтгэн Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд нэгтгэн брокер, диллерийн компаниар дамжуулан хүргүүлсэн. Мөн компанийн цахим хуудас болон хөрөнгийн биржийн цахим хуудасаас нээлттэй мэдээлэл авах бүрэн боломжтой байгаа. Өнөөдрийн хурал дээр товчхон танилцуулга хийнэ. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан хэлэлцэх асуудал, дэгийн дагуу хурлаа үргэлжлүүлье.

Хэлэлцэх асуудал:

Монгол базальт ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Хурлын дарга А.Энхгэрэл: Дүгнэлт батлахтай болон компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, цаашид хийгдэх ажлууд, тогтвортой хөгжлийн зориултуудыг ерөнхийд нь танилцуулъя.

Дэлгэцийн харагдах байдал товч:



Компанийн хараат бус хөндлөнгийн аудитын компанийг Жэй Пи Эй Глобал монголиа ХХК-ийг ТУЗ сонгож, гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон байдаг ба тус компани 2022 оноос “Нексиа Интернэшнл” гэдэг дэлхийд ТОП-8 ордог аудит, нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээний тэргүүлэгч компанийн Монгол Улс дахь албан ёсны хараат бус гишүүн байгууллагаар ажиллаж, Сангийн сайдын тушаалаар компанийн оноосон нэрийг Нексиа Глобал монголиа аудит ХХК болгож өөрчилсөн юм. Манай компанийн хараат бус хөндлөнгийн аудитын дүгнэлт нь Англи, Монгол хэл дээр СТОУС-ын дагуу хийгдэж гарсан, энэ нь компанийн цаашдын хэрэгжүүлэх олон улсын төсөл, санхүүжилтэд чухал ач холбогдолтой юм. Мөн өнөөдрийн ХЭХ дээр хөндлөнгийн аудитын компанийн аудитор Бат-Оргил хүрэлцэн ирсэн ба та бүхэн сонирхсон асуултаа асууж болохоор байгаа шүү. Мөн бид энэ жил Компанийн байгаль орчин нийгэм засаглалын үнэлгээний тайланг анх удаа гаргах гэж мэргэжлийн байгууллагатай нь хамтран ажиллаж байна. БОНЗ-ын үнэлгээ, түүний үр дүнгээр хэрэгжүүлэх, сайжруулах ажлууд маань бүгд компанийг шинэ хөгжил дэвшилд хүргэх зорилготой гэдгийг та бүхэнд дуулгахад таатай байна.

Үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн үзүүлэлтийг хурлын материалд дэлгэрэнгүй хавсаргана. Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг ТУЗ-ийн дарга Л.Ариунболд танилцуулна гэснээр хурал үргэлжлэв.

ТУЗ-ийн дарга Л.Ариунболд: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг уншиж танилцуулав. Дүгнэлт баталсан Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол болон дүгнэлтийн эх хувийг хурлын материалд хавсаргав.

Хурлын дэгийн дагуу эхний хэлэлцэх асуудлын талаар асуулт хариултыг явуулъя. Асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигч Р.Лхагвадорж: Надад хэд хэдэн асуулт байна. Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл сайн байсан байна гэж үзлээ. Гэхдээ компанийн хувьцааны ханш анх худалдан авсан үнээсээ буурсан байгаа энэ талаар ямар дүгнэлт хийж байгаа вэ? 2.Ногдол ашгийн бодлого гэж компанийн дүрэмд тусгасан зүйл байна уу? 3. Хөрөнгө оруулалтын өгөөжийг яагаад буруу тооцож байна вэ? Анхны үнэтэй харьцуулахад хөрөнгө оруулалтын өгөөж байхгүй байгаа шүү дээ, энэ дээр тайлбар байна уу?

А.Энхгэрэл: За баярлалаа, маш зөв зүйтэй асуулт байна. Ногдол ашгийн өгөөжийг тухайн зарласан үеийн ханшид харьцуулан өгөөжийг тооцдог журамтай. Анх гаргасан ханшийг харгалзаж үзэхгүй, анх гаргасан үнэтэй та хувьдаа харьцуулж үзэж болно. 2022 онд жишээлбэл 2022 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараах эсэхийг ТУЗ нэгдүгээр улирлын хурлаар тухайн үеийн зарласан ханш хэд байгаагаар харьцуулж өгөөжийг тооцож баталдаг. Бусад ХК-ууд бүгд энэ жишгээр тооцдог, бид энэ жишгийг дагадаг. 2022 оны цэвэр ашгаас ногдол ашиг 20 төгрөг тараасан, 2019 онд 2 төгрөг байсан гэж өсөлтийг тооцсон. Ер нь бол таны санал зөв, бид нар анх гаргасан хувьцааны үнэтэй өнөөдрийн хувьцааны үнэ, ногдол ашгийн өгөөжийг тооцож өгч болно. Хувьцаа эзэмшигчдийнхээ үр өгөөжийг өсгөх зорилго байнга байгаа, гэхдээ өнөөдрийн зах зээлийн нөхцөл байдал бусад хүчин зүйлээс шалтгаалан хараахан байнгын бүх төлөвлөгөөгөө биелүүлэх боломжгүй байна. Жил жилээр л боломжоороо сайжруулах бодлоготой ажилладаг. Ногдол ашгийн өгөөжийг ТУЗ-аас баталсан ногдол ашгийн бодлоготоо нийцүүлэн тухайн жилийн ашигт ажиллагаанаас хамаарч тараахаар шийдвэрлэнэ гэсэн зарчимаар шийдвэрлэдэг. 2023 онд ямар хэмжээний үйл ажиллагаа, ямар хэмжээний бүтээн байгуулалт хийж байгаатайгаа уялдуулан компанийг санхүүгийн аливаа эрсдэлд оруулахгүй байхаар тооцон ногдол ашиг тараах шийдвэрийг гаргадаг. Өнгөрсөн жилийн банкны хадгаламжийн хүү, Монгол банкны бодлогын хүү зэрэгт уялдуулдаг, аль болох хадгаламжийн хүүгээс илүү байлгахаар шийдвэрлэдэг байгаа шүү.

Ханш яагаад унаад байгааг нээлттэй зах зээл, биржийн арилжааны хувьд ийм тийм болоод уналаа гэж хэлж чадахгүй байна. Бидний эцсийн зорилго бол үйлдвэрлэлийг төлөвлөгөөний дагуу явуулах, бизнес төлөвлөгөөний үр дүнг давуулан биелүүлэх, үр өгөөжтэй ашигтай ажиллая гэж боддог. Энэ үйл ажиллагааны эцсийн үр дүнг манай хувьцаа эзэмшигчид хараад, үнэлээд ойлгоод цаашдын хөгжилд дэвшилтэй санал нийлээд, компаниа өөрийн тодорхой хэмжээнд үнэлж, хувь хувьдаа өөрсдийнхөө шийдвэрийг гаргах хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг: Би энэ хүнтэй санал нэг байна. Бид анх хувьцаа авахдаа 380 төгрөгөөр авсан. Цаашдаа бараг 1000 хүрнэ гэж амалсанд итгээд авсан, одоо 1000 хүрэх нь байтугай, 160 байснаа одоо дөнгөж 200 гараад явж байна. Одоо 10,20 төгрөгийн ногдол ашиг өгсөн гэж байна, бидний алданги энэ тэрийг бодож болох уу? Хүнд үйлдвэрийг хөгжүүлж байгаа гэдэгтээ өнөөдрийг хүртэл дуугай байгаа. Хоёрдугаарт 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн тоо гэдгийг дэвтэр дээр бичээгүй байна.

А.Энхгэрэл: Хурлын дэвтэрт 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг оруулсан байгаа. Компанийн үйл ажиллагааны улирал бүр гарч байгаа тайланд тусгагддаг, хөрөнгийн биржийн сайтад байнга нээлттэй мэдээлэл байгаа.

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг: Танайх анхны хөрөнгийн үнэлгээг ямар байгууллагаар хийлгэсэн бэ? Энийг хэлж болох уу? Ер нь хувьцааг 1000 хүрнэ гэж бодоод авсан байгаа.

ТУЗ-ийн дарга Л.Ариунболд: Энэ дээр би нэмэлт тайлбар хийе. Ер нь бол хувьцааны үнэ ханш бид нарын ч бас санаа зовоож байгаа зүйл. Надад ч бас асуулт байдаг. Бид сайн ажиллаад байхад яагаад хувьцааны үнэ өсөхгүй байна гэж??? Хувьцаат компани болж байгаа 3 том зарчим бол нэгдүгээрт компанийн өсөж хөгжих том суурь, хоёрдугаарт Монголын хөрөнгийн бирж энэ дээр мэргэжлийн дүгнэлт хийх ёстой. Би бол бид нарын хийсэн ажил, сүүлийн таван жилийн ажлын үр дүн, өсөт, үзүүлэлтүүд, арматурын үйлдвэр шинээр байгуулсан, шинэ технологи инноваци нэвтрүүлж үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулсан амжилттай ажиллаж байна. Компанийн үйл ажиллагаа сайжирч, ашиг орлого сайжирч тэлэлт үүсч байж хувьцааны үнэ ханш өсдөг нь бүх л улс орны зарчим байдаг. Монголын зах зээл жижиг, өөрөө өөрийнхөө хувьцааг худалдаж аваад ханшаа өсгөх, тогтвортой байдалд байлгах тохиолдол байсан энийг санхүүгийн зохицуулах хорооноос шалгаж тогтоож байсан. Бид тийм алхам хийхгүй, хийх нь өөрөө хууль бус. Бидний зорилго бол үйл ажиллагаа, үйлдвэрлэлээ сайн явуулж, үнэ цэнээ өсгөх, компанийн өгөөжийг сайжруулах, аиг орлогоо нэмэгдүүлэх зорилготой байгаа. Анх хувьцаа гаргахад 3,4 тэрбум төгрөгийн борлуулалттай байсан, одоо бол 14,2 тэрбум төгрөгийн борлуулалттай болсон, дунд нь короно вирус, дайн байлдаан, хил гааль хаалттай зэрэг нөхцөл байдал байсан ч гэсэн амжилттай ажиллаж борлуулалт, үр ашиг 4,1 дахин өссөн өнөөдрийн түвшинд хүрсэн. Гэтэл яагаад хувьцааны үнэ ханш өсдөггүй юм бэ? Би ч бас өөрөөсөө асууж л байна. Бидний хийж чадах зүйл сайн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сайн үйлдвэр байгуулах л явдал. Инженер технологи суурьтай компанийн гол зорилго нь ерөөсөө л технологи, инновациа сайжруулж энэ зах зээл дээр өрсөлдөх юм, бидний чадах л зүйл энэ. Энэ хэмжээгээр бол тэлэлт өсөлт байна уу, байна... яагаад хувьцааны ханш өөрчлөгдөхгүй байна гэдгийг бас л хараад л сууж байна. Уг нь дэлхийн зах зээлийн хууль бол энэ компани өсч байна, үр ашиг нь сайжирч байна гээд хувьцааны худалдан авалт ихсэж, үнэ ханш өсөх ёстой. Эсвэл бидний оролцож байгаа хөрөнгийн зах зээл ном дүрмээрээ биш байна уу? Бидний хийж чадах зүйл нь сайн ажиллаж, үйлдвэрлэлээ хөгжүүлэх, эсвэл шударга биш тоглолт хийх л байна, бид шударга замаа л сонгож авч байна.

Би ХХК байхад нь 10 жил ажиллаад өнөөдрийн санхүүгийн үзүүлэлтэд хүрч чадаагүй, тавхан жилийн дотор өнөөдрийн гүйцэтгэх удирдлага, ажилтнууд маань энэ үр дүнд хүрсэн. Өнөөдөр зах зээл дээр гурилаас эхлээд бүх бүтээгдэхүүний үнэ нэмэгдээд, цемент, арматурын үнэ тэнгэрт тулж байхад барилгын амин сүнс болсон дулаалгын материалын үнийг 30 хувь хүртэл хямдруулж чадлаа. Өнөөдөр бидний энэ үзүүлэлтийг Засгийн газар жишиг болгож байна, үндэсний үйлдвэрлэл гэдэг чинь энэ байхгүй юу, технологи гэдэг чинь энэ байхгүй юу? Яагаад нэг талдаа бүх зүйлийн үнэ өсч байхад, нөгөө талдаа 30 хувиар үнээ бууруулж чадаад байна, инноваци гэдэг чинь энэ шүү дээ. Бид 14 тэрбум төгрөгийн борлуулалтыг энэ жил 20 тэрбум болгох л зорилго, энэ бүхэн чинь хувьцааны худалдан авалтыг нэмж, хувьцааны ханш өсгөх 200 саяын хөрөнгө чинь, 2 тэрбум болохыг үгүйсгэхгүй юм. Хүнсний салбар хамгийн өндөр эрэлттэй, нийт зах зээлийн 36 хувийг хангаж байгаа Газар шим компани 2,6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байхад манайх чинь барилгаас хамааралтай, баилга зогсонги байдалд ороход бид дагаад зогсонги болох боломжтой. Гэхдээ бид эрчим хүчний салбар, айл өрхийн байшингийн дулаалга гэж бүтээгдэхүүний нэр төрөл, технологийг сайжруулж зогсонги байдалд орохгүй гэж ажиллаж байна. Би энэ компанийг өөрийн амь амьдрал, нэр төртэйгээ холбож өдий хүртэл тордож авч явж байгаа. Бид яагаад гадна дотны компанитайгаа хамтраад нженерүүдээ сургаж хөгжүүлж ажиллаж байна, бидэнд бэлэн бэлтгэгдсэн инженер байдаггүй, дандаа өөрсдөө нарийн мэргэжлийн инженерээ бэлдэж ажиллаж байна. Жишээлбэл 2018 онд манай инженерүүд 2 сая төгрөгийн цалинтай байсан бол өнөөдөр 4,5 сая төгрөгийн цалинтай байна, ингэж байж бид үйлдвэрлэлийг авч явж байгаа. Тааралдсан хүн болгон л хэлж байна, санхүүгийн үзүүлэлт бүх зүйл өсөлттэй сайн байхад яагаад хувьцааны ханш ийм байна гээд гайхдаг. Үнэхээр энэ тухай мэдэхгүй байна. Гэхдээ судалгаагаа бол хийнэ, хандалтаа хийж л байна. Манай хөрөнгийн бирж дээрхи тоглогч нар хэр шударга байгаа юм, бид нарын хийж бүтээж байгаа, зах зээлийн үнэ цэнийг өсгөх үзүүлэлтийг голчилж байна уу, эсхүл цөөхөн төгрөгийн арилжааны үзүүлэлт байна уу?

Гэхдээ ингэлээ гээд шантрахгүй, улам л сайн ажиллахыг хичээнэ, өөр сонголт байхгүй. Таны асууж байгаа асуулт бол орой бүр Блүүмбергийн мэдээг хараад л өөрөөсөө асуудаг зүйл, зүтгээд л байдаг, ажиллаад л байдаг, яасан хөдөлдөггүй тоо вэ гэж... гэхдээ шантрахгүй, ханш өснө, өөрчлөгдөнө гэдэгт итгэлтэй байна. 3 тэрбум төгрөгийн борлуулалттай байсан компанийг хувьцаа эзэшигч та бүхэн орж ирсэнээр 14 тэрбумын борлуулалттай болгож чадлаа, 200 саяын ашигтай байсан компани 2 тэрбумын ашигтай ажиллаж, 1,1 тэрбум төгрөгийн ногдол ашиг тарааж байна, энэ бол үнэн. Хөндлөнгийн аудитаар батлагдаад гарсан үнэн зүйл. Энэ бүгдээс хувьцааны ханш 1000 хүрэхгүй юмаа гэхэд 500 төгрөг байхаар хөдөлмөр, бүтээмж зарцуулсан үзүүлэлт байна л гэж ойлгодог.

Хувьцаа эзэмшигч Сүхбаатар: Би барилгын салбарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан. Анх нээлттэй болоход хувьцаа худалдан авсан. Компанийн үйл ажиллагаа ямар байна, бүтээгдэхүүний нэр төрөл ямар байна гэж хардаг. Миний хувьд анх удаа хуралд сууж байна, хямд дээр нь хувьцаагаа нэмж авья гэсэн бодолтой байгаа, өнөөдөр шийдвэрлэнэ. Нэгж хувьцааны дансны үнэ хэдэн төгрөг байгаа вэ? Гэж асуух гэсэн юм.

А.Энхгэрэл: Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд эздийн өмч 30 тэрбум төгрөг болж өссөн байгаа. Үүнийг нийт хувьцаатай харьцуулахад 530 орчим төгрөг байна. Дансны үнэ 400-500 төгрөгт байнга өсч байгаа. Компани үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж суурилуулах, үл хөдлөх хөрөнгө бий болох бүрт капиталжилт хийж байгаа. Өнгөрсөн таван жилийн хугацаанд 10 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг өөртөө хийсэн байгаа учир нэгж хувьцааны дансны үнэ байнга өсч байгаа.

Хувьцаа эзэмшигч Сүхбаатар: Аан за за сайн байгаа юм байна.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа: Би олон жил танай хувьцаа эзэмшигч байна. Монгол улсын хэмжээнд нийгмийн хөгжлийн асуудлаар маш их хэмжээний ажлууд хийдэг. Танайхаас яьуулж буй хүүхдийн хөгжлийн асуудлыг ТУЗ-ийн гишүүдээс хэн хариуцдаг вэ? Хүний нөөцийн албанаас хэн хариуцдаг вэ? Тэр хүмүүстэй уулзаж санал хэлэх хэрэгтэй байна.

А.Энхгэрэл: ТУЗ-ийн хувьд нийгмийн хариуцлага, тэр дундаа хүүхдийн хөгжлийн асуудлыг ТУЗ-ийн дарга Ариунболд өөрөө хариуцдаг. Харин компани дээр хүний нөөцийн менежер Нарангарав хариуцаж байгаа.

Таван богд капитал ҮЦК төлөөлөгч Мөнх-Эрдэнэ: Би компаниа төлөөлөөд болон манай харилцагчдыг төлөөлж асууж байгаа шүү. ТУЗ-ийн 9 гишүүдээс хэдэн хүн ирсэн байгаа вэ?

А.Энхгэрэл: 9 гишүүнээс 7 гишүүн ирсэн байна. Хан Гю Бунг гишүүн БНСУ-ын иргэн, хэд хоногийн өмнө нутаг руугаа буцсан тул танхимаар ирээгүй байна. ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Нямдорж өнөөдөр ээж нь зүрхний хагалгаанд орж байгаа учир хүндэтгэн үзэх шалтгаантай ирж амжаагүй байна. Бусад гишүүд маань танхимд байна, та бүхэн асуулт байвал асууж болно.

Таван богд капитал ҮЦК төлөөлөгч Мөнх-Эрдэнэ: Термобазальт гэж ямар статустай компани вэ? Монгол базальтын охин компани уу? Тусдаа компани уу? 2022 оны санхүүгийн тайлангаас харахад Термобазальт ХХК-д 4527 метр хөвөн нийлүүлсэн байна. Энэ нь их хэмжээний болон ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл мөн үү? Энэ тал дээр тайлбар хийнэ үү?

А.Энхгэрэл: Термобазальт ХХК-ийн хувьцааг Монгол базальт ХК эзэмшдэггүй, тусдаа хуулийн этгээд байгаа. Хувьцаа эзэмшигч нь П.Сайнбилэг. Хөвөн нийлүүлсэн хэлцэл болон санхүү бүртгэлийг хөндлөнгийн аудитын байгууллага шалгаж дүгнэлтдээ тусгасан. Нэг удаагийн хэлцэл байгаа нь их хэмжээний хэлцлийн хэмжээнд хүрэхгүй. Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болно гээд ТУЗ-ийн

тогтоолоор зөвшөөрөл өгөөд хийсэн, санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт бүгд тусгагдсан байгаа. Гэхдээ үйл ажиллагааны тайлан, хурлын дэвтэрт тусд нь гаргаагүй байгаа. Цаашид мэдээлж байх тухай анхааръя.

Таван богд капитал ҮЦК төлөөлөгч Мөнх-Эрдэнэ: Анх IPO хийж байхад 2022 онд 5,4 тэрбум төгрөгийн ашигтай ажиллана гэж төлөвлөсан байна, 2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байгаа нь 50 хувьд хүрэхгүй байна. Боруулалтын орлого яахад 14,2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Ашиг цаашид тогтвортой байж чадах уу? Ашиг сүүлийн 2 жилд өссөн байна, тогтвортой өсөх үү? Ногдол ашгийн бодлого дээрээ хамгийн багадаа тийм хувь байна, ямар ч ашигтай ажилласан бай 30, 40 хувь тараана гэж тусгаж болохгүй юу? Энэ нь жижиг хувьцаа эзэмшигчдийн хүлээлтийг хангах байх.

А.Энхгэрэл: Зөв зөв, яг үнэн. 2022 оны үйл ажиллагааны хүрээнд бид санхүүгийн 5 жилийн үзүүлэлтийг харьцуулж үзэхэд бид жил бүр үйлдвэрлэлийн өртгийг жил бүр 5-8 хувь бууруулж ирсэн байгаа. Хамгийн анх 2018 он болон 2019 оны жилийн эцсийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь нийт борлуулалтын орлогод эзлэх хувь 86, 79 хувь гэж байсан бол 2022 оны эцэст борлуулсан бүтээгдэхүүний өртөг 65 хувь болж буурсан байна. Тэгэхээр энэ 4 жилийн хугацаанд инфляцын өндөр хувь, валютын ханшийн өндөр савалгаанд ББӨ-ийг жил бүр хамгийн багадаа 10 орчим хувь бууруулж ирээд дахин 5 хувь бууруулах гэж энэ жил төлөвлөсөн байгаа. Компанийн үйл ажиллагааны үндсэн зорилгын нэг нь өртөг бууруулах, Яаж өртөг бууруулах вэ гэхээр мэдээж үйлдвэрлэлийн инноваци, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлуудаараа дамжуулж бүтээмж нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг өсгөх, нэг цагт үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, шаардлагагүй зардлыг багасгаж, шаардлагатай газарт нь хөрөнгө оруулалт хийхийг ТУЗ-дээр байнга зөвлөлдөж шийдвэрлэдэг ба Бизнес төлөвлөгөөндөө тусгаж баталдаг. Хүнд үйлдвэрлэлийн хувьд өртөгийг 63 хувьд хүргэнэ гэдэг бол нилээд амбицтай төлөвлөгөө. Арилжааны банкны зээлийн хүү, бодлогын хүү, инфляци зэрэг нь өртөгт шууд нөлөөлдөг, тиймээс эх үүсвэрийн зардлыг багасгаж ББӨ-ийг багасган цэвэр ашгийн орон зайг өсгөнө гэж үзэж байгаа. Бид өнгөрсөн хугацаанд аль болох үйл ажиллагааны зардлыг огт өсгөхгүй, харин ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх бодлоготой байсан. Тэгэхээр ногдол ашгийн бодлого дээр жил бүр тэдээс тэдэн хувь тараахаар зарлана гэж тавиагүй байгаа нь үнэхээр эргэлзээтэй, эрсдэлтэй зах зээлд ажиллаж байгаа хүнд үйлдвэрийн салбарт эргээд түүнийгээ барьж ажиллаж чадах уу? Амлалтаа биелүүлэх хэцүү нөхцөлд компаниа оруулаад төлбөрийн чадварын эрсдэлд орчих вий гэдэг эргэлзээтэй. Тэгэхээр дахин судалж, бодлого боловсруулж нэмэлт зохицуулалт хийж, аль болох эрсдэл багатай сонголт хийх нь зөв гэж үзэж байна.

Таван богд капитал ҮЦК төлөөлөгч Мөнх-Эрдэнэ: Компанийн тухай хуульд ногдол ашиг тараах үндсэн үзүүлэлтийг алдахааргүй үед ногдол ашиг тараах шийдвэр гаргадаг. Тэгэхээр ногдол ашгийн бодлогыг зөв тодорхойлох нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарт илүү ойр байдаг, хувьцааны үнэ ханш өсөхөд бас нөлөөлнө гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч Шигшээ: Би барилгын дулаалгын ажил хийдэг. Өнөөдрийн байдлаар Монгол базальт ХК-ийн бүтээгдэхүүн м.кв нь 2740 төгрөг байна. Хүмүүс Росторгийг илүү сонгоод байдаг, яагаад гээд асуухаар илүү үнэтэй байна гэж хариулдаг. Жижиг барилгуудад яагаад үнэтэй байдаг вэ? Тийм болохоор Росторг,Шинайдаг сонгоод байдаг. Базальтын үнэ буурвал бүтээгдэхүүний борлуулалт ихсэх гээд байна, бас нэг зүйл үйлдвэрлэлийн орчин, ажиллах нөхцлийг сайжруулсан уу?

А.Энхгэрэл: Та сая хурал дээр ярьсан мэдээллийг дутуу ойлгосон байх шиг байна. 2023 оны 4 сард 1 м.кв бүтээгдэхүүнийг 8000 төгрөгөөс эхлээд нягтаасаа хамаарч өөр өөр байхаар үнийг бууруулж баталсан байгаа. Энэ нь Оросоос орж ирж байгаа чулуун хөвөн биш шилэн хөвөнтэй харьцуулахад хямд байгаа. Монгол улсад импортоор орж ирж байгаа хөвөнгүүд нь шилэн хөвөн- шилэн хөвөн нь шил, кварцаас гаргаж

авдаг, шатдаг, хонины ноосон орц байхгүй, энэ бүтээгдэхүүнийг хэргэлдэг зах зээл нь амины орон сууц, хаусд хэргэлдэг, маш жижиг зах зээлтэй. Хоёрдугаарт Монгол улсын сандарт, барилгын норм ба дүрмээр шилэн хөвөнг олон нийтийн барилга, орон сууцны дулаалгаар хэрэглэхийг зөвшөөрдөггүй. Яагаад гэвэл хүйтэн сэрүүн нөхцөлтэй, галын эрсдэлтэй нөхцөлд кондинсаци үүсгэдэг, өндөр эрсдэлтэй байдаг. Дараагийн импортоор БНХАУ-с орж ирж байгаа хүнд үйлдвэрийн хаягдал шаарган хөвөн байгаа. Энийг эрдэс хөвөн гэж нэрээр оруулж ирж байгаа ч энэ нь чулуун хөвөн биш юм. Цэвэр базальт чулуун хөвөн дулаалгын материал импортоор орж ирдэггүй. Яагаад гэвэл технологийн маш нарийн өндөр өртөг бүхий үйлдвэрлэл шаарддаг, үнэтэй бүтээгдэхүүн гэж үздэг. ОХУ, БНХАУ-ын дотоодод худалдаалж буй чулуун хөвөн нь маш үнэтэй, импортоор оруулж ирэх боломжгүй байдаг. Тэгэхээр манайхан нэр томъёоны ялгаа болон хуулийн цоорхойг ашиглан шаарган хөвөн эрдэс хөвөн гэж нэрээр оруулж ирж чулуун хөвөнтэй адилтган харьцуулж хямд үнээр худалдаж, өөрөөр хэлбэл төөрөгдөлд оруулж барилгын салбарт оршсоор байгаа. Энэ бүгдээс шалтгаалан чулуун хөвөн технологийн өөр арга технолгиор үйлдвэрлэсэн импортын бүтээгдэхүүнүүдтэй өрсөлдсөөр ирсэн. Өнөөдрийн байдлаар 1 м.кв бүтээгдэхүүн 8000 төгрөг байгаа нь импортын шилэн хөвөнтэй харьцуулахад хямд болсон байна. Манай бүтээгдэхүүн м.кв тутамдаа 30 кг-ийн нягттай байгаа, гэтэл хүмүүсийн хямдхан гэж олзуурхаад байгаа шилэн хөвөн нь метр тутамдаа 8 кг нягттай байдаг. Үүний эсрэг бид сургалт, танин мэдүүлэх ажлуудыг зохион байгуулж, байшинг нь дулаалах, зах зээл дээр байгаа бүтээгдэхүүнтэй нь харьцуулж үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг байнга хэрэгжүүлж байна. Гэхдээ хамгийн чухал нь Барилгын тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, барилгын норм ба дүрэм зэргийг мөрдүүлэх нь чухал юм, бид олон жилийн турш бизнесийнхээ эрх зүйн орчныг сайжруулахаар төлөвлөн хэрэгжүүлж ажиллаж ирсэн, үүний үр дүнд бүрдүүлж чадсан. Одоо төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалт, дүрэм журам мөрдүүлэх зэрэг ажлууд дутагдалтай байгаа. Энэ бүгд жигд явагдах юм бол таны эрсдэл гэж үзээд байгаа зүйл бүрэн шийдэгдэх боломжтой, бүтээгдэхүүний борлуулалтыг ч нэмэгдүүлэх хүчин зүйл болох юм, болно гэсэн хүлээлттэй байгаа.

Хувьцаа эзэмшигч Энхмэнд: Базальт Файбер үйлдвэрийн нийт үнэлгээ хэд вэ? Ногдол ашгийн мөнгөн хөрөнгийг 6 сарын 30-ны дотор тараах боломжтой юу? Компанийн тайлан, үзүүлэлтээс хөрөнгө оруулагч нар компанийг сонирхож эхэлж байна, нэмж хувьцаа гаргах, бонд гаргах бодлого төлөвлөгөө ойрын хугацаанд бий юу?

А.Энхгэрэл: Базальт файбер арматурын үйлдвэрийн эхний шугам өнгөрсөн жил ашиглалтад оруулсан. Төлөвлөсөн хөрөнгө оруулалтаар хамгийн багадаа 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн. Одоогийн байдлаар 2,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн, зах зээлийн судалгаа, үйлдвэрлэлийн туршилт судалгаа хийгдсэн байна. Одоо олон улсын шинжилгээний байгууллагад дээжээ явуулж, стандартыг хэрхэн хангаж байгаа, давуулж байгаа талаар дүгнүүлэхээр өгсөн байгаа. Базальт арматур нь жилдээ 250-350 тэрбум төгрөгийн борлуулалтын зах зээлтэй. Өнөөдрийн бүтээн байгуулалтаар жилдээ 2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байна гэсэн хүлээлттэй байна. Энэ бүтээгдэхүүн маань манай зах зээлд шинэ бүтээгдэхүүн учир барилгын норм ба дүрэмд хүлээн зөвшөөрүүлэх, тусгуулах шаардлага үүсч байна. Гэхдээ ган арматурыг орлуулах гэж зорихгүй ядаж арматурын хэрэглээний 30 орчим хувийг файбер болон шилэн арматураар орлуулах боломжтой гэж үзэж байгаа. 5 жилийн хугацаанд борлуулалт, үнэлгээг нэмэгдүүлнэ, зах зээлийн боломжийг харж байгаад шугам дамжлагыг нэмнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Л.Ариунболд: Энэ асуудал дээр би нэмэлт тайлбар өгье. Дэлхийн зах зээл дээр файбер арматур угаасаа ган арматуртай өрсөлддөггүй. Ган арматурын зэвэрдэг сул талд нь хэрэглэх боломжтой, тухайлбал барилгын подваль хэсэг, гүүр хоолой, лотки, цэвэр усны байгууламж гэх мэтэд илүү хэрэглэдэг. Тухайлбал зураг төслийн компаниуд файбер арматур хэрэглэх хэсгийг тусд нь зурж өгөх хэрэгтэй. Файбер арматур нь төмрөөс 4 дахин хөнгөн, 3 дахин бат бөх учир насжилтыг уртасгадаг тул бетон хийцлэлд илүү

хэрэглэгддэг. Мөн амины орон сууцанд илүү хэрэглэдэг яагаад гэвэл долгион. Дамжуулж, соронзон орон үүсгэдэггүй давуу талтай гэхмэтчилэн өөрийн гэсэн зах зээл, сегменттэй юм. Тэрнээс биү төмөр арматуртай өрсөлдөх гээд, тэрний зах зээлээс авах гээд, хямдхан байх гээд байх шаардлагагүй юм. Шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд таниулахад дунджаар 3 жилийн хугацаа шаардлагатай байдаг. Одоогийн байдлаар бид ямар ч байсан стандартаа батлуулсан, норм дүрэмд тусгаж байна. Зураг төслийн компаниудтай хамтран ажиллаж, наад зах нь инженерүүд тооцоолол хийж сурах хэрэгтэй байгаа. Технологийн хувьд брицалдах чадварыг сайжруулсан хамгийн сүүлийн үеийн шугам, тоног төхөөрөмжийг суулгасан байгаа. Чулуун хөвөнг ч бас анх гаргахад энэ шат дамжлагуудыг туулаад л хэрэглэгчдэд таниулаад л өнөөдрийн хөгжилд хүрсэн байгаа. Өнөөдрийн 8030 төгрөг гэдэг үнийг гаргахын төлөө сүүлийн 3 жилийн турш маш олон ажлуудыг хийсэн байдаг. Амины орон сууц барьж байгаа худалдан авагч нарт зориулсан асуудлыг шийдвэрлэхээр 3 жил ажилласан байна.

А.Энхгэрэл: Компанийн үйл ажиллагааны салбар нь барилгын салбар байгаа, салбарын онцлог, борлуулалттай уялдуулан жил бүрийн 12 сарын 31-нд багтаан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид тараасан байгаа. Эхний хагас жилд ногдол ашгийг тараах боломжгүй байдаг нь манай үйлдвэрийн хамгийн их зардал гардаг мөчлөг нь эхний хагас жил, харин сүүлийн хагас жил буюу зун, намрын улиралд борлуулалт нэмэгдэж мөнгөн хөрөнгийн эргэлт сайжирдаг тул ногдол ашгийг тараахад тохиромтой байдаг. Тийм болохоор эхний хагас жилд биш, сүүлийн хагас жилд ногдол ашиг тараахаар шийдвэрлэдэг байгаа, энэ нь үйл ажиллагааны онцлогтой шууд хамааралтай юм. Эхний хагас жилд тараах шийдвэр гаргах нь компанийг санхүүгийн эрсдэлд оруулахыг ч үгүйсгэхгүй юм. 2023 онд нэмж хувьцаа гаргах төлөвлөгөө байхгүй. Засгийн газрын хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан ногоон бонд гаргах шалгуурыг хангаж байгаа компани мөн, гэхдээ маш их судалгаа, тооцоолол хийж энэхүү шийдвэрийг гаргана гэж бодож байна. Нөгөө талаар бид арилжааны банкуудтай илүү сайн харилцаатай хамтран ногоон зээлийн эх үүсвэрт хамтран ажиллах нь бонд гаргахаас илүү бага зардалтай тусч байна. Хэрэв арилжааны банкуудтай хамтрах нь бонд гаргахаас илүү зардалтай байгаа тохиолдолд бид бонд гаргах сонголтыг хийх бүрэн боломжтой. Энэ нь тухайн үеийн зах зээлийн үнэлгээ, ханш, хүүгийн бодлогоос шууд хамааралтай юм.

Одоо гол гол асуултууд нилээд яригдах шиг боллоо. Дараагийн асуудалдаа орьё.

Хувьцаа эзэмшигч Лхагвадорж: Одоо санал шүүмждээ орьё. Дэгээрээ явья. Компани бол сайн ажиллаж байгаа, Монголд байгаа цорын ганц үйлдвэрлэл би энийг маэдэж байгаа. Гэхдээ яагаад зах зээл дээр хувьцааны ханш өсөхгүй байна, түрүүн өөрөө хэлж байна өгөөжгүй учраас гэж... Өгөөжгүй гэдэг нь ТУЗ муу ажиллаж байна. Манай ТУЗ-д СЗХ-д ажиллаж байсан, гишүүн байсан гавъяат эдийн засагч байна, хөрөнгийн биржид ажиллаж байсан хүн байна, тэгэхээр ногдол ашгийн өгөөжийн бодлогыг зөв тодорхойлж чадахгүй байна. Тухайлбал Хаан банк ногдол ашгийн бодлогоо шууд зарлаж байна, бид нар жилийнхээ ашгийн 40-50 хувийг шууд ногдол ашигт өгнө гэж, яагаад ингэж зарлаж болохгүй байна. Тухайлбал ногдол ашгийн хэмжээ арилжааны банкнуудын хадгаламжийн дундаж хүүгээс буурахгүй гэдэг ч юм уу, манайд бол ногдол ашиг нь заримдаа цэвэр ашгийн 100 хувь, заримдаа 50 хувь байх жишээний, энийг ТУЗ-ийн хэдэн гишүүд сууж байгаад дураараа шийдээд байна гэж харж байна. Тэгэхээр хүн ийм тогтворгүй зүйлд хөрөнгө оруулалт хийхгүй, тийм болохоор ногдол ашгийн бодлогоо маш тодорхой болгох хэрэгтэй. Компани сайн ажиллаад байдаг, зах зээлээ эзэлсэн байдаг, гэтэл анх хувьцаа авсан хэдэн хүний асуудлыг шийдэж чадахгүй, хувьцааны ханш муу байдаг. Түрүүн ногдол ашгийн хувь, өгөөжийг буруу тооцож байна. ТУЗ-д Шаравсамбуу, Шаравсамбуугийн Энхтөр гэж байгаа нь аав, хүү хоёр юм уу?

ТУЗ-ийн гишүүн Б.Шаравсамбуу: үгүй ээ үгүй, биш, юу гэж тийм тэнэг юм хийхэв дээ...хүүтэйгээ хамт сууж байдаг.

Хувьцаа эзэмшигч Лхагвадорж: Ногдол ашгийн бодлогыг зөв болгоё, дурааараа ТУЗ нэг 100 хувь тараагаад, нэг 50 хувь тараагаад баймааргүй байна. Дүрэмдээ ногдол ашгийг тодорхой оруулж өгмөөр байна гэсэн санал байна.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа: Компанийн үйл ажиллагаа, ашигт ажиллагаа, ногдол ашиг, хувьцааны үнэ өмөхгүй байгаа гэх зэргээс дүгнэхэд Монголын хөгжлийг эдийн засгийн аргаар биш, улс төрийн аргаар удирдаж ирсэнтэй шууд холбоотой. Монгол базальт ХК бол Ноу-хау дандаа шинээр гаргаж ирдэг, хамгийн сүүлийн жишээ гэхэд Европын холбооны банктай хамтран үйлдвэр барих гэж байна. Үйлдвэр, банк хоёрын ялгаа маш том гэдгийг хүн бүр мэднэ. Банктай адилтган хувьцаа, ногдол ашиг гэдгийг дүгнэх боломжгүй. Хоёрдугаарт миний санал танай дэргэд хэрэгжиж буй хүүхэд хөгжлийн маш том төсөл байгаа, түүнийг хоёр янзаар хөгжүүлмээр байна. Сургуулийн өмнөх боловсрол болон бага насны хүүхдүүдэд, нөгөө талаас өндөр настнуудад зориулж Юнимат төслийг хэрэгжүүлээчээ гэж хүсч байна.

ТУЗ-ийн гишүүн Б.Шаравсамбуу: Би нэг хоёр гурван санал тайлбар хийе. Юуны өмнө өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцэж байгаа гол асуудал бол ТУЗ-ийн улирал бүрийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн балансыг дэлгэрэнгүй үзэж болно. Өнөөдрийн тараасан материал бол маш товчхон байгаа. Ногдол ашиг тараах хэмжэ, бодлогын хувьд ямар шалтгаанаар цэвэр ашгийн 53,6 хувь тараасан бэ, яагаад 100 хувь тарааж болохгүй вэ гэдгийг ТУЗ-ийн хурал дээр маш олон талаас нь нарийн ярилцаж бодож шийдсэн байдаг. Хаан банк жил бүр 40-50 хувь гэж хэлсэн, бид үүнэээс илүү тараахаар л ажиллаж байна. Хувьцааны үнэ 380-аас яагаад 160, 200 болов оо гэдэг дээр макро эдийн засаг буюу компаниас шалтгаалаагүй маш олон хүчин зүйлүүд нөлөөлж байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй. Анх хувьцаа гаргаж байх үед валют төгрөгийн харьцаа 2000 орчим төгрөг байсан, өнөөдөр 3500 гараад явж байна. Энэнтэй холбогдуулаад дизель, шатахууны үнэ ямар үнэтэй болсон билээ, компанийн зардлын хувь уурхайгаас түүхий эд татахаас эхлэн түлш шатахууны зардал гарч байгаа, мөн төгрөгийн ханш уналттай холбоотой ажилтнуудын цалин нэмэгдсэн, ялангуяа ИТА нарын тогтвортой байдлыг хангах зорилгоор цалинг нэмдэг гэх мэтээр олон үйл ажиллагааны зардал бодитоор байнга өсч байгаа. Зардлуудыг бололцоотой бүх талаар хэмнэх бодлого баримталж, гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, хийж ирсэн. Ногдол ашгийн хэмжээг цэвэр ашгийн 53,6 хувь гэдэг дээр компанийн санхүүгийн эх үүсвэр, банкны хадгаламжийн хүү гэх мэтээр, өнөөдөр компанийг гэнэтийн асуудлаас сэргийлэх, эрсдлийн сан байгуулах гэх зэрэг, компани зардал өндөртэй эх үүсвэр ашиглах биш, өөрийн хөрөнгийг ашиглах гэх мэт олон асуудлаар дүгнэлт хийж ТУЗ энэхүү шийдвэрийг гаргадаг. ТУЗ-ийн зүгээс өгч байгаа үйл ажиллагааны болон санхүүгийн дүгнэлт нь цөөн өгүүлбэрээр бичсэн мэт боловч бүх асуудлыг хэлэлцэж нэгтгэн ярилцаж бичдэг гэдгийг хэлмээр байна.

А.Энхгэрэл: Та бүхэн цахим бүртгэлээр дамжуулж, саналаа цахимаар өгч болно шүү. Эхний асуудал хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал 2: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Хурлын дарга А.Энхгэрэл: Монгол базальт ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон ТУЗ нь компанийн хөгжлийн бодлого, стратегийн зорилтыг хангаж, тогтвортой хөгжлийг ханган ажиллаж ирсэн ба 2021 онд ээлжит болон ээлжит бус 5 хурал хийж, 11 асуудал шийдвэрлэн 6 тогтоол гаргасан байна. Харин 2022 онд ээлжит болон ээлжит бус 5 хурал, эчнээ санал хураалт 2 удаа явуулж нийт 12 асуудлаар 11 тогтоол баталж, хэрэгжилтийг нь хангасан байна. Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хорооноос явуулсан компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн 2022 оны хагас жилийн үнэлгээгээр 62 оноо буюу 75%-иар үнэлэгдсэн. Үүнээс хойш компанийн засаглалыг сайжруулах, жижиг хувьцаа эзэшигчдийн эрх ашгийг хамгаалах олон бодлого, дүрэ журам баталгаажуулсан ба 2023.05.01-ээс хойш хийгдэх дахин үнэлгээгээр илүү сайжрах байх гэдэгт итгэлтэй байна.

2021-2022 онд ажилласан ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, компанийн дүрэмд заасан мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага болон бусад шаардлагыг бүрэн хангаж байгаа бөгөөд бүрэн бүрэлдэхүүнээр нь улируулан нэр дэвшүүлж хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсан. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох нь дараах давуу талуудтай гэж ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо болон ТУЗ үзсэн байгаа. Үүнд:

- Гишүүд нь компанийн үйл ажиллагааны онцлог, хөгжлийн стратегийг бүрэн ойлгосон
- Нягт уялдаа холбоотой багаар ажиллах арга барил хэвшсэн
- Хараат бус гишүүний шаардлага хангасан 5 гишүүнтэй
- Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх дүрэм, журам, бодлогын баримт бичгийг баталгаажуулсан

Мөн Компанийн тухай хуульд зааснаар санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн хугацаанд ТУЗ-д нэр дэвшүүлэх ямар нэгэн санал хувьцаа эзэмшигчдээс ирээгүй болохыг дурьдах нь зүйтэй байх.

Хурлын дэвтэрт ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт болон гишүүдийн мэргэжил туршлага гэх мэтийг дэлгэрэнгүй тусгасан, мөн өнөөдрийн хуралд нэр дэвшигч нар ирсэн байгаа, та бүхэн асуух зүйлээ асууж болно. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр П.Нямдорж, Ш.Энхтөр, Ч.Зоригтбаатар нар нэр дэвшиж байна. Ер нь манай ТУЗ-д хараат бус гишүүний шаардлага хангаж буй 5 гишүүн байгаа, гэхдээ компанийн дүрэмд ердийн 6, хараат бус 3 гишүүн гэж заасан байгаа тул Г.Ганзориг, Б.Шаравсамбуу гишүүд маань ердийн гишүүн гэж нэр дэвшсэн байгаа.

Та бүхэн хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт, саналаа хэлж болно. Хэдүүлээ нилээд удаан хугацааг өнгөрөөсөн байгаа тул энэ удаа цагаа баримталж явья.

Хувьцаа эзэмшигч Лхагвадорж: Анхны хурал бил үү, хоёр дахь хурал дээр би компанийн ТУЗ-д орох ямар боломж байна гэж асууж байсан. Энэ нэг тийм хаалттай байдлаар, бид оролцох боломжгүйгээр яваад байна. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвших тухай нээлттэй зарласан уу?

А.Энхгэрэл: Бололгүй яахав. Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д санхүүгийн жил дууссанаас хойш өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй нийлж 5 хувиас илүү хувьцаа эзэмшигч нь ТУЗ-д нэр дэвшүүлэх саналаа санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор саналаа гаргана. Хувьцаа эзэмшигч нь хараат бус гишүүн байх боломжгүй, ердийн гишүүнд нэр дэвшүүлэх саналаа өөрсдөө гаргах боломжтой. ХЭХ хуралдуулах шийдвэр нь 60 хоногоос хойш гарч байгаа, тэр хүртэл өргөдөл хүсэлт хүлээн авч болно, ТУЗ-ийн нарийн бичигтэй холбогдоод анкет, засаглалын сертификатаа явуулж болно. Түүнийг ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо хянаад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэх дүгнэлт гаргаж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцдэг байгаа.

Хувьцаа эзэмшигч Д.Энхжаргал: Санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор санал гаргана гэдгийг мэдээгүй, сүүлд хүсэлт, бичиг баримтаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргад явуулсан. Би одоо нэрээ дэвшүүлж болох уу?

А.Энхгэрэл: Болно. Таны нэрийг дэвшүүлэх, саналын хуудаст өөрчлөлт оруулах эсэхийг энд ирсэн хувьцаа эзэмшигчдээс нээлттэй санал хурааж шийдвэрлэх боломжтой. Одоо бол ТУЗ-ийн тогтоолд өөрчлөлт оруулах боломжгүй, шууд ХЭХ-ын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулах, санал хураах талаар шийдэх байх...

Хувьцаа эзэмшигч Д.Энхжаргал: Намайг Данзанбалжирын Энхжаргал гэдэг. Би банк, санхүүгийн салбарт 30 гаруй жил ажиллаж байгаад одоо олон улсын байгууллагад зөвлөхөөр ажиллаж байгаа. Би Монгол базальт ХК-ийн 7153 ширхэг хувьцаа эзэмшдэг, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор ТУЗ-ийн ердийн гишүүнд нэрээ дэвшүүлмээр байна. Хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангах байх, материалыг ТУЗ-ийн нарийн бичигт явуулсан. Намайг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлж, санал хураах жагсаалтад оруулж өгөөч ээ гэж хүсч байна.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа: Ер нь компаниудын жишгийг харахад хуулийнхаа дагуу 60 хоногийн хугацаандаа нэрээ дэвшүүлээд орж ирдэг. Шууд хувьцаа эзэмшигчдийн хурал дээр ингэж нэрээ дэвшүүлж болохгүй байх аа. Өмнө нь ТУЗ-д нэрээ дэвшүүлж ТУЗ-д орж ажиллаад үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэрхэн удирдах уу? Олон улсын төслийг хэрхэн удирдах уу гэх мэтээр зорилгоо тодорхойлох ёстой байх. Одоо хууль тогтоомжийг ойлгуулах цаг хугацаа нь ХЭХурал биш гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч Д.Энхмэнд: Би ч гэсэн өөрийнхөө нэрийгдэвшүүлж болох уу? Сайн байцгаана уу. Намайг Энхмэнд гэдэг, би Бумбат алтай үнэт цаасны копанийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. Анкет сертификатаа сая явуулсан байгаа. Монгол базальт ХК-ийн ТУЗ-д нэр дэвшүүлж байгаа гол шалтгаан нь хувьцааны үнэ ханш яах бол, хувьцаа эзэмшигчдийн нөхцөл байдал яаж өөрчлөгдөх үү? Шинээр хөрөнгө оруулалт хэрхэн татах уу? Гэх мэтээр ирээдүйн хөгжилд нэмэр болох асуудлаар хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах чиг үүргийг гүйцэтгэнэ. Миний харж байгаагаар компани маань технологи, инноваци бүтээгдэхүүний талаар мэдээлэл сайн өгч байгаа ч хувьцаат компанйн хувьд хөрөнгө оруулагчдад өгөх мэдээлэл дутагдалтай байх шиг байдаг. Энэ талаар илүү анхаарч бодлогын түвшинд ажиллаж чадна гэж өөрийгөө нэр дэвшүүлж байна.

А.Энхгэрэл: Сая нэрээ дэвшүүлэх хүсэлт гаргаж байгаа хоёр хувьцаа эзэмшигчийн асуудлыг шийдэж саналын хуудаст нэрийг оруулах эсэхийг нээлттэй санал хураалтаар шийдвэрлье гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа: Одоо энд байгаа хувьцаа эзэмшигч хэдхэн хүн байна. Ихэнх хүмүүс цахим саналаа өгөөд явчлаа. Хэрэв ХЭХ дээр шууд энэ асуудлыг хэлэлцэхбол түрүүний Лхагвадорж гэж хүн ч бас нэр дэвшүүлэх хүсэлтэй байсан. Тэр хүний эрх ашиг зөрчигдөхөөр болж байна. Тийм болохоор одоо нэмж нэр дэвших саналыг хүлээн авч болохгүй гэж бодож байна.

Тооллогын комиссын дарга Б.Болортуяа: Өнөөдрийн хуралд хүрэлцэн ирсэн 28 хүнээс одоогийн байдлаар 17 хүн саналаа өгөөд хурлаас явсан байна. Энэ саналд ТУЗ-ийн гишүүдийг сонгох кумулятив санал өгсөн хуудас ч бас байна. Тэгэхээр одоо нэр дэвшүүлэх нь өмнө нь санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналыг хүчинтэйд тооцох, тооцохгүй дээр маргаан үүсгэж болох юм.

Л.Ариунболд: Энэ тал дээр би нэг санал хэлмээр байна. Өнөөдөр нэрээ дэвшүүлж байгаа Энхжаргал, Энхмэнд нар нь хэн хэн нь ойрын харилцаатай ажилладаг хүмүүс байж хуулийн хугацаанд саналаа, баримт бичгээ өгөөд боломжийг ашигласангүй вэ? Яагаад зеаавал цагийг нь тулгаж өнөөдрийн хурал дээр ингэх болов оо гэдгийг гайхаж байна. Уг нь ажил хэргийн холбоотой, ойр байдаг хүмүүс тулгахгүйгээр эртхэн санал хүсэлтээ өгсөн бол ТУЗ-д нэрээ дэвшүүлэх бүрэн боломж байсан байна гэж бодож байна. Одоо зарим хувьцаа эзэмшигчид цахим саналаа өгөөд, зарим нь явсан байхад нэр дэвшүүлж байгаа нь процессын алдаа болж, нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөж болохоор байна. Тийм болохоор энэ удаад нэр дэвшүүлсэн хүмүүстээ саналаа аваад явах нь хууль зөрчихгүй гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа: Нэр дэвшүүлэх эсэх, ТУЗ-ийн гишүүдийн сонгуульд оролцуулах эсэх дээр санал хураахгүй нь зөв гэж үзэж байна. Бусад хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг бодох хэрэгтэй. Тиймээс хууль журмынхаа дагуу нэр дэвшүүлсэн хүмүүс дээрээ саналаа хураагаад шийдвэрээ гаргах саналтай байна.

А.Энхгэрэл: Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн хурал дундуур гарах, явах нь өөрийнх нь эрхийн асуудал байдаг. Хувьцаа эзэмшигчид саналаа өгөөд явсан байна. Одоо энд байгаа хүмүүсээр энэ асуудлыг шийдэх үү гэдэгт санал хураая.

Нээлттэй гар өргөж санал хураасаар олонхийн саналаар хурал дундуур өөрсдийн нэрээ дэвшүүлсэн хувьцаа эзэмшигчдийг нэр дэвшүүлэх, саналын хуудаст оруулах асуудлыг хэлэлцэхгүй байхаар шийдвэрлэсэн болно.

А.Энхгэрэл: За нэгэнт нэмэлт нэр дэвшигчийн асуудлыг шийдвэрлэхгүй болсон тул одоо нэр дэвшүүлсэн байгаа хүмүүс дээрээ кумулятив санал хураалтаа явуулъя. Дэгийн дагуу дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал 3: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээ батлах тухай

Хурлын дарга А.Энхгэрэл: Монгол базальт ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн сар бүрийн цалин, нэмэгдэлийг хүснэгтээр танилцуулъя. Өнгөрсөн 2 жилийн жишгээр санал оруулж байгаа. Мөн Төлөөлөн удрдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн гишүүнийг ажлын гүйцэтгэлийг үнэлэх боломжтой болсон тул тус үнэлгээний дагуу 2 гишүүнийг урамшуулж байхаар жилийн 15 сая төгрөгт багтаах саналыг ХЭХ-д оруулж байна.

ТУЗ-ийн гишүүдийн цалин		Хэмжээ /төгрөг/
Тогтмол цалин /сар бүр/	Үндсэн	1,000,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	200,000
	ТУЗ-ийн дэргэдэх хорооны даргын нэмэгдэл	100,000
Урамшуулал /жилд 1 удаа/	ТУЗ-ийн гишүүдийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр 2 гишүүнийг урамшуулах	15,000,000

Асуулт, хариулт- гараагүй.

Хурлын дарга А.Энхгэрэл: Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт байхгүй бол санал хураалтаа явуулж, хурлын шийдвэрээ нэгтгэе.

Тооллогын комиссын дарга Б.Болортуяа: Санал хураалтын хугацаа дууслаа. Санал хураалтын дүнг танилцуулъя. 2023.04.17-ны өдрийн Тооллогын комиссын тогтоол дугаар 2 уншиж танилцууллаа. Үүнд:

Компанийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалт, 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол базальт” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах эсэх: нийт 23 хувьцаа эзэмшигч санал өгсөнөөс зөвшөөрсөн-22, түдгэлзсэн-1 буюу санал хураалтын дүнгээр санал өгсөн хувьцаа эзэмшигчид 95,6% зөвшөөрсөн тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох кумулятив аргаар хураасан санал хураалт нь Компанийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.3-т заасан шаардлагыг хангаж, санал өгсөн хувьцаа эзэмшигчид журмын дагуу санал өгсөн тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох санал хураалтын дүнгээр төслийг 95,6% зөвшөөрсөн байх тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.

Тооллогын комиссын дарга Б.Болортуяа гэжээ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн нь:

Нэгдүгээр асуудал: Монгол базальт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2023.04.17-ны өдрийн дугаар 1 “Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.11-д заалт, 2023 оны 04 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хоёрдугаар асуудал: Монгол базальт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2023.04.17-ны өдрийн дугаар 2- Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.9-д заалт, 2023 оны 04 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр
    1. Лхагважавын Ариунболд
    2. Галбадрахын Ганзориг
    3. Бадарчийн Шаравсамбуу
    4. Пүрэвбанзрагчийн Сайнбилэг
    5. Ариунболдын Энхгэрэл
    6. Хан Гю Бунг нарыг тус тус сонгосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр
    1. Шаравсамбуугийн Энхтөр
    2. Чансаагийн Зоригтбаатар
    3. Пүрэвсүхийн Нямдорж нарыг тус тус сонгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон бусад хууль тогтоомжийг баримтлан компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг үүрэг болгосугай.

Хэлэлцэх асуудал 3- Монгол базальт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2023.04.17-ны өдрийн дугаар 3 - Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.15-д заалт, 2023 оны 04 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг төслийн дагуу нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг сар бүр тооцон, хууль тогтоомжийн дагуу олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Б.Болортуяа/-д зөвшөөрсүгэй.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Билгүүн